



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 16адар

Дугаар №332.

Есенбулаг сум

Г Төр, захиргааны байгууллагуудын
ажлын цагийн хуваарьт зохицуулалт
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 41.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 84.1, 84.2, 94.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, цаг ашиглалтыг сайжруулах, амралт чөлөөт цагийг зохицуулах зорилгоор аймгийн хэмжээнд төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийг 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал эхлэх цагийг 08:00 цагт, тараах цагийг 17:00 цагт, цайны цагийг 12:00 цагаас 13:00 цаг байхаар өөрчилсүгэй.

2. Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд мэдээлэн, сурталчлан таниулах ажлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын удирдлагуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т тус тус даалгасугай.





କାହାରେ ଏହା କାହାରେ ନିରାକାରୀ ଛି ସମ୍ବନ୍ଧିତ କଥାରେ କିମ୍ବା
କାହାରେ ଏହା କାହାରେ ନିରାକାରୀ ଛି କଥାରେ କିମ୍ବା

$$\frac{m/s}{kg/m^3} = \frac{kg/m/s}{kg/m^3}$$



የኢትዮ - አስተኛ አኗኝነት ስ/ ዲጂዢ/ ቁልጊያን/ ገ/ መብትና
መጥቃቅ/ የሆኑ/